



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/128

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 42 дугаар зүйлийн 42.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын 1.5.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 03/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, төрийн үйлчилгээнд хамрагдахад шаардагдах үнэмлэхийг олгох арга хэмжээний зардалд 1,896,000 (нэг сая найман зуун ерэн зургаа мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 1,896,000 (нэг сая найман зуун ерэн зургаа мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100278